



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2021 оны 06 сарын 15 өдөр

Дугаар 194

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл  
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1, "Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах арга хэмжээ"-ний тухай Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолын 1.а дахь заалт, Ховд аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2020 оны 191, 192, 193 дугаар тогтоол, 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Ховд аймгийн өмчөөс шилжүүлсэн 34 нэрийн 111,020,398.00 (нэг зуун арван нэгэн сая хорин мянга гурван зуун ерэн найман) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг төрийн өмчид хүлээн авч, "Баруун бүсийн эрчим хүчний систем" төрийн өмчит хувьцаат компанийн охин компани "Ховд цахилгаан түгээх сүлжээ" ХХК-нд эзэмшүүлж, бүртгэлд тусгахыг зөвшөөрсүгэй.

2.Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Насантогтох, "Баруун бүсийн эрчим хүчний систем" төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Д.Ганхүлэг, "Ховд цахилгаан түгээх" ХХК-ийн гүйцэтгэх захирал Ш.Арстан, Ховд аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга Ш.Нохойжав нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө хүлээлцэх, байгууламжийн дээрх газрыг баталгаажуулах ажлыг байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2021 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ



132001447

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2021 оны 6 дугаар сарын 1-ны өдрийн  
19/ дугаар тогтоолын хавсралт

**"ХОВД ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ" ХХК-ИЙН  
ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

Д/д	Хөрөнгийн нэр	Марк	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Балансын үнэ
					(төгрөг)	
<b>1.Ховд аймаг, Зэрэг сум, Хөндлөн, Бургасан багын нутаг дэвсгэрт 14 дүгээр ангиллын 0,4 кВт хүчин чадал бүхий Цахилгаан дамжуулах агаарын шугамын зориулалттай барилга байгууламжийн шинэчлэлт болон айл өрхийг шинээр холбох</b>						
1	Төмөр бетон тулгуур	УКШ 12.35.19	ш	10	450,000.00	4,500,000.00
2	Төмөр бетон тулгуур	УКШ 10.30.17	ш	1	420,000.00	420,000.00
3	Төмөр бетон тулгуур	УКШ 9.27.15	ш	20	380,000.00	7,600,000.00
4	Сип кабель	/3*16+1*25/	ш	1,300	4,500.00	5,850,000.00
5	Трансформатор	SBN -11	ш	1	4,500,000.00	4,500,000.00
6	Трансформатор	МВ-25	ш	1	3,500,000.00	3,500,000.00
7	Тоолуурын хайрцаг	6 толлууртай	ш	6	115,672.00	694,032.00
8	Тоолуурын хайрцаг	4 тоолууртай	ш	4	95,000.00	380,000.00
9	Агаарын дэд өртөө	АТП-63	ком	1	7,300,000.00	7,300,000.00
10	Агаарын дэд өртөө	АТП-25	ком	1	6,400,000.00	6,400,000.00
11	Тросстой татагч		ш	40	20,000.00	800,000.00
12	Баригч		ш	40	20,000.00	800,000.00
13	Буултын кабель	4*10	м	90	7,500.00	675,000.00
14	Тоолуур	PDS-100A	ш	1	240,000.00	240,000.00
15	Газардуулага		ком	1	340,340.00	340,340.00
16	Хөнгөн цагаан утас	АС-35	м	3,000	1,000.00	3,000,000.00
<b>ДҮН</b>						<b>46,999,372.00</b>
<b>2. Ховд аймгийн Зэрэг сумын Эхэн багт "Эрчим хүчний трасс тавих ажил</b>						
17	Төмөр бетон тулгуур	УКШ 9.27.15	ш	30	460,000.00	13,800,000.00
18	Тулаас		ш	4	250,000.00	1,000,000.00
19	Татуурга		ком	6	150,000.00	900,000.00
20	Сип кабель	/3*25+1*35/	м	1100	6,500.00	7,150,000.00
21	Сип кабель	/3*16+1*25/	м	800	5,500.00	4,400,000.00
22	Тоолуурын хайрцаг	6 тоолууртай	ш	10	115,672.00	1,156,720.00
23	Тоолуурын хайрцаг	4 тоолууртай	ш	10	95,000.00	950,000.00
24	Оройн комут		ш	42	30,000.00	1,260,000.00
25	Татагч		ш	46	20,000.00	920,000.00
26	Баригч		ш	50	20,000.00	1,000,000.00
27	Буултын кабель	4*10	м	150	9,500.00	1,425,000.00
28	25А Автомат		ш	60	3,500.00	210,000.00
29	Тоолуур	PDS-100A	ш	1	259,286.00	259,286.00
<b>ДҮН</b>						<b>34,431,006.00</b>
30	Төмөр бетон хөлтэй модон тулгуур		ш	45	201,556.00	9,070,020.00
31	Сип кабель	/3*25+1*25/	м	3000	5,500.00	16,500,000.00

32	Оройн комут		ш	45	60,000.00	2,700,000.00
33	Татагч		ш	10	22,000.00	220,000.00
34	Баригч		ш	50	22,000.00	1,100,000.00
<b>ДҮН</b>						<b>29,590,020.00</b>
<b>НИЙТ ДҮН</b>						<b>111,020,398.00</b>
<b>НИЙТ ДҮН</b>						<b>(нэг зуун арван нэгэн сая хорин мянга гурван зуун ерэн найман төгрөг)</b>